



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив хорин гурав” ХХК-ийн гаргаж буй 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 30 хүртэл жилийн хугацаатай, орон сууцны зээлээр баталгаажсан нийт 900,168 /есөн зуун мянга нэг зуун жаран найм/ ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

2. Баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцөлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “МИК актив хорин гурав” ХХК /Т.Мөнхжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “МИК актив хорин гурав” ХХК /Т.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүй болохыг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хамтарсан А/167/203 тоот тушаалаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх, бүртгэх тухай журам”-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртгэлд бүртгүүлж, 4 сарын дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх;

3/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Энэ тогтоолын 1-д заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай:

- 1/ Баталгаат үнэт цаасаар баталгаажсан зээлийн багцад буй зээлдэгчдийг Хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын дагуу ипотекийн даатгалд бүрэн хамруулах;
- 2/ Хороонд судалгаа, шинжилгээнд шаардлагатай холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж ирүүлэх;
- 3/ Анх бүртгүүлсэн барьцаа хөрөнгийн үнэлгээний нийлбэр дүн, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны урт хугацаатай өглөгийн дүн, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн талаарх мэдээллийг сар бүр тогтмол Хороонд ирүүлж байх.

5. Энэхүү тогтоолын 2-т заасан гэрээний дагуу үнэт цаас худалдан авсан хөрөнгө оруулагчдын үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, бүртгэлийн талаарх мэдээллийг улирал бүр гарган ирүүлж ажиллахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Сангийн яам /Ч.Хүрэлбаатар/-д дараах арга хэмжээ авч ажиллахыг тус тус зөвлөсүгэй:

- 1/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч банканд Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд тогтмол хяналт тавьж ажиллах;
- 2/ Банканд олгосон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөд тавьж буй хяналт шалгалтын тайлан, мэдээг Хороонд ирүүлэх;
- 3/ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүжилтийн эх үүсвэрийн зардлыг төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэж, зах зээлийн зарчмаар хөгжүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллах.

7. Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв эсэхийг үнэт цаас гаргагч “МИК актив хорин гурав” ХХК /Т.Мөнхжаргал/, хөрөнгө итгэмжлэн удирдагч “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/ болон энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий анхны үүрэг гүйцэтгүүлэгч 9 арилжааны банк хариуцахыг дурдсугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
42 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“МИК актив хорин гурав” ХХК-ийн гаргаж буй орон
сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөгөөр/	Эзлэх хувь
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас I	100,000	165,723	1.0%	30 хүртэл жил	16,572,300,000	18.4%
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас II	100,000	544,984	4.5%	30 хүртэл жил	54,498,400,000	60.5%
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас III	100,000	99,433	13.0%	30 хүртэл жил	9,943,300,000	11.1%
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	90,028	10.5%	30 хүртэл жил	9,002,800,000	10.0%
Нийт	100,000	900,168	-	-	90,016,800,000	100%

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
92 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

“МИК актив хорин гурав” ХХК-д орон сууцны зээл багцлан
худалдаж буй анхны үүрэг гүйцэтгүүлэгчид

№	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөг/	Зээлийн дансдын тоо	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ
1	“Богд банк” ХХК	1,248,135,975.26	22	1.39
2	“Голомт банк” ХХК	13,895,238,020.85	245	15.44
3	“Капитрон банк” ХХК	6,249,522,941.24	104	6.94
4	“Төрийн банк” ХХК	20,517,313,074.91	266	22.79
5	“Улаанбаатар хотын банк” ХХК	2,133,045,443.28	26	2.37
6	“Хаан банк” ХХК	19,320,042,449.87	379	21.46
7	“Хас банк” ХХК	11,093,388,989.76	219	12.32
8	“Худалдаа хөгжлийн банк” ХХК	12,310,349,452.39	140	13.68
9	“Чингис хаан банк” ХХК	3,250,331,346.90	38	3.61
Нийт		90,017,367,694.46	1,439	100.00